

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



2020: ХҮНИЙ ЭРХ БА УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ



ГИШҮҮД, ДЭМЖИГЧДЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн зөрчлийг төгсгөл болгохын төлөө кампанит ажил өрнүүлдэг 150 гаруй орны 7 сая гаруй гишүүд, дэмжигчид, хүний эрх хамгаалагчдыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний хүсэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид байж, ихэнхдээ гишүүд, олон нийтийн хандиваар санхүүждэг.

Монголын Эмнести Интернэшнлийн эрхэм гишүүд, дэмжигчдээ,

Эмнести Интернэшнл Парламентын сонгуульд нэр дэвшигчдийн талаар ямар нэг байр суурь илэрхийлэхгүй ч харин бид дараагийн Парламент улс эх орондоо, дэлхий дахинд хүний эрхийг дэмжиж, хамгаалах ёстой гэж үздэг. Мөн аль ч засгийн газар гадаад, дотоод бодлогодоо хүний эрхийн асуудлыг нэн тэргүүнд оруулах ёстой.

Аливаа парламент нь хүний эрхэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх чадалтай тул шинэ парламентыг бүрдүүлэх сонгуулийн уур амьсгал нь хүний эрхийн байгууллагуудад боломж болоод сорилыг авчирдаг.

2020: Хүний эрх ба УИХ-ын сонгууль хэмээх энэ гарын авлага нь гишүүд дэмжигч болоод тус байгууллагыг төлөөлөх хэн нэгэн сонгуультай холбоотойгоор юу хийж болох, болохгүй талаарх удирдамжийг багтаасан болно.

СОНГУУЛЬ БА ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ТУХАЙ ЗАЙЛШГҮЙ МЭДЭХ ОЙЛГОЛТ

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн байгууллага бөгөөд аливаа улс төрийн нам, нэр дэвшигч, засгийн газар, эсвэл улс төрийн үзэл баримтлалыг дэмжих буюу эсэргүүцдэггүй.

Энд та бүхэнд, 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг явуулах удирдамжийг хүргэж байна. Хэрэв та бүхэнд асууж тодруулах зүйл байвал mongolia.amnesty@gmail.com хаягаар хандана уу.

- **Эмнести Интернэшнлийн хараат бус байдлыг онцлох.** Эмнести Интернэшнл нь 1961 оноос хойш намын үзэл баримтлалаас ангид байж дэлхийн улс орнуудад хүний эрхийг хамгаалж ирсэн. Иймд сонгуульд нэр дэвшигч, эсвэл олон нийттэй харилцахдаа Монголын Эмнести Интернэшнл нь аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчийг эсэргүүцэх буюу дэмждэггүй, нам бус байгууллага болохыг тодорхой ойлгуулж, сонгуулийн сэдэвтэй холбоотой гарч байгаа Эмнести Интернэшнлийн материалууд дээр энэ тодотголыг хэрэглэж байх.
- **Та хувийнхаа улс төрийн үзэл бодлыг Монголын Эмнести Интернэшнлийн албан ёсны мэдэгдэл, үзэл баримтлалаас ангид байлгах.** Хэрэв та социал орчинд Монголын Эмнести Интернэшнлийг төлөөлөх гэж байгаа бол та хувийн социал хаягнаасаа ялгаатай, Эмнеститэй холбоотой зориулалтын хаягтай байх ёстой. Та энэ хаягнаасаа төрийн албанд нэр дэвшигчийг эсэргүүцсэн эсвэл санал болгосон аливаа мэдээллийн талаар пост хийх, твиттерээр жиргэх, ийм мэдээллийг бусадтай хуваалцах ёсгүй.

Та хувийнхаа хаягнаас улс төрийн үйл ажиллагаа явуулах эрх чөлөөтэй ба харин энэ нь байгууллагыг төлөөлж байгаа гэсэн сэтгэгдэл төрүүлэхээргүй байх хэрэгтэй. Мөн та Монголын Эмнести Интернэшнлийн байр, тоног төхөөрөмжийг хэрэглээгүй байх (тухайлбал суурин болон зөөврийн компьютер, гар утас болон суурин утас, принтер болон ажлын байр гэх мэт). Монголын Эмнести Интернэшнлийн үйл ажиллагаанд оролцож байгаа бол нийтийн албанд нэр дэвшигчийг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн улс төрийн намын ямар нэг эд зүйл, хувцас өмсөхгүй. Тухайлбал ажилтан, сайн дурын ажилтан байгууллагыг төлөөлж жагсаал, цуглаан, үйл ажиллагаанд оролцох гэж байгаа бол аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа харуулсан малгай, футболк, тэмдэг болон бусад хувцас, эд зүйл хэрэглэхгүй байх.

- **Монголын Эмнести Интернэшнлийн нэр бүхий сошиал медиа хуудсыг нэр дэвшигчийг дэмжих, эсвэл эсэргүүцэхэд хэрэглэхгүй.** Та хувь хүнийхээ зүгээс аль нэг нэр дэвшигчийг, улс төрийн намыг дэмжих эрх чөлөөтэй ч харин та хэн нэг нэр дэвшигчийн төлөө сайн дурын ажил хийж байгаа бол, эсвэл бусад намын улс төрийн үйл ажиллагаанд оролцож байгаа бол Эмнести Интернэшнлийг илэрхийлсэн, тодорхойлсон ямар нэг эд зүйл, хувцас өмсөж болохгүй. Мөн та Эмнестигийн үйл ажиллагаанаас гадуур, намын ажилд оролцож байгаа бол байгууллагын зүгээс биш, хувь хүн гэдгээрээ оролцож, ярьж байгаа болохоо маш тодорхой ойлгуулах ёстой.
- **Хэрэв та Монголын Эмнести Интернэшнлийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа бол аль нэг нэр дэвшигчийг дэмжих буюу**

эсэргүүцэхгүй. Үүнд нэр дэвшигчийг ил, далд эсэргүүцэх эсвэл хүлээн зөвшөөрөх ёсгүй. Хэн нэгэн нэр дэвшигчийг эсэргүүцсэн, эсвэл дэмжсэн мессэж, постер, твиттер, графикайг бусадтай хуваалцахгүй. Монголын Эмнести Интернэшнлийг төлөөлөх үедээ та нэр дэвшигчийн байр суурьт халдах, эсвэл түүнийг нь хүлээн зөвшөөрөх ёсгүй.

- **Сонгуульд нэр дэвшигчидтэй бүгдтэй нь тэгш харилцах.** Нэр дэвшигч нарт хандсан аливаа үйл ажиллагаа бүх нэр дэвшигч нарт хамаатай байх ёстой. (Бид асуулга явуулах бол бүх нэр дэвшигч нарт хандуулах). Хэрэв бид олон нийтэд хандсан хурал, үйл ажиллагаанд нэр дэвшигчийг урих гэж байгаа бол тухайн сонгуульд нэр дэвшиж буй бүх нэр дэвшигчийг урих ёстой.
- **Асуудлыг өргөн хүрээнд баримтлах.** Монголын Эмнести Интернэшнл нь зөвхөн нэг асуудлаар ажилладаггүй бөгөөд бид нэр дэвшигчдийн хүний эрхийн асуудлаарх өргөн хүрээний үзэл баримтлалыг сонсох сонирхолтой. Нэр дэвшигчдийг ялгаатай харагдуулж болохоор нэг асуудлыг илүү тодотгох зэрэг нь асуудлыг дэмжих, эсвэл эсэргүүцэхийг асууж буй аль нэг намын асуулга мэт ойлгогдож болзошгүйг анхаарах.
- **Нэр дэвшигчдээс амлалт нэхэхгүй.** Нэр дэвшигчээс хэрэв сонгогдвол тодорхой нэг асуудлыг дэмжинэ гэсэн амлалт авахыг хориглодог. Өөрөөр хэлбэл зөвхөн тийм/үгүй гэж хариулж болохоор эсвэл зөв хариултыг таамаглаж болохоор асуулт тавихгүй. Харин үүний оронд нэр дэвшигч нарт асуулга тавьж, байр сууриа тодорхой тайлбарлах боломж олгох.
- **Асууж болно, хэлэлцүүлж болохгүй.** Танхимын цугларалт, хэлэлцүүлэг нь

бидний анхааран ажиллаж байгаа асуудлаа гаргаж тавих сайхан боломж юм. Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр бид нэр дэвшигчдээс тодорхой хүний эрхийн асуудлаарх үзэл баримтлалыг нь асууж болох ч тэдний өгсөн хариулт дээр тайлбар хийх, эсвэл Монголын Эмнести Интернэшнлийн өмнөөс тэдэнтэй маргаан хэлэлцүүлэг өрнүүлэхгүй.

- **Сэрэмж, болгоомж алдах.** Хэрэв та сонгуулийн үеэр сошиал медиагаар нэр дэвшигчийн байр суурьтай холбоотой захидал бичих, нэр дэвшигчийг батлах, шүүмжлэх эсвэл хүлээн зөвшөөрөх, нэр дэвшигчийн үйл ажиллагаа/сан арвижуулалтын үйл ажиллагаа, эсвэл намын улс төрийн үйл ажиллагаанд оролцох бол та Монголын Эмнести Интернэшнлийг төлөөлж биш, хувь хүнийхээ зүгээс оролцож байгаа болохоо маш тодорхой, ойлгомжтой байлгах ёстой. Энэ бодлогыг Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд, сайн дурын ажилтнууд, дадлагажигч, ажилтан, Удирдах зөвлөлийн гишүүд бүгд мөрдөнө.

УИХ-ЫН СОНГУУЛЬ: БОЛЗОШГҮЙ АСУУЛТАД ХАРИУЛАХ НЬ

Эмнести Интернэшнл сонгуульд нэр дэвшигчдээс хэнийг дэмжиж байгаа вэ?

Эмнести Интернэшнл нь нам бус байгууллага учраас аль ч сонгуулийн үеэр хэн нэгэн нэр дэвшигчийг дэмжих эсвэл эсэргүүцдэггүй.

Магадгүй хэн нэг нэр дэвшигч бусдаасаа илүүтэй танай байгууллагын байр суурийг дэмждэг байж болно. Энэ өнцгөөс харахад Эмнести Интернэшнлийн зорилтуудыг цаашид хэрэгжүүлэхэд аль нэр дэвшигч илүү тохирох вэ?

УИХ-ын сонгуулиар хэн гарч ирэхээс үл хамааран Эмнести Интернэшнл нь дараагийн/шинэ/ парламентэд Монгол улс болон дэлхий дахины хүний эрхийн асуудлаар ажиллахыг уриална.

Сонгуульд нэр дэвшигчид олон янзын асуудлаар ялгаатай үзэл бодолтой байдаг. Гэвч дараагийн засгийн газрыг хэн тэргүүлэхээс үл хамааран бид хүний эрхийн асуудалд анхаарал хандуулахыг шаардана.

Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчдийн тухайд тэд хэн нэг нэр дэвшигчийг нөгөөгөөс нь илүү дэмжих ёстой юу?

Бусад иргэд хувь хүмүүсийн адил Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд нь хувь хүн гэдгээрээ хүссэн хүнээ дэмжих боломжтой. Сонгуулийн талаарх тэдний үзэл бодол бол хувь хүнийх бөгөөд Эмнести Интернэшнлийн байр суурь болохгүй. Эмнести Интернэшнл нь аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчийг эсэргүүцэх, эсвэл дэмжихгүй.

СОНГУУЛИЙН ҮЕЭР ӨРНҮҮЛЖ БОЛОХ ХҮНИЙ ЭРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сонгуулийн өмнө нэр дэвшигчдэд сурталчилгаа хийх тодорхой хугацаа олгогддог бөгөөд энэ үед бүх нэр дэвшигчид өөрсдийн тойргийн сонгогчидтой уулзаж, мөрийн хөтөлбөрөө танилцуулан, хэлэлцүүлдэг. Энэ үйл ажиллагаа нь тухайн тойргийн хүмүүс ч гэсэн аливаа хүний эрхийн асуудлаар санаа зовниж байдгийг харуулах, мөн хүний эрхийн байгууллагууд бидний өдөр тутамдаа тэмцэж байдаг хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг УИХ-ын гишүүдэд ятгах нэн чухал боломж юм.

УИХ-д сонгогдсон бүх гишүүд нэн тэргүүнд хүний эрхийг хүндэтгэн, хамгаалж, хэрэгжүүлэх ёстой. Улс орны засгийн газрууд бодлого, практиктаа дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн хэм хэмжээг баримтлахаа баталгаажуулах ёстой. Эдгээр хүний эрхийн хэм хэмжээ нь дүрвэгсэд, улс төрийн орогнол эрэгч, галт зэвсгийн хүчирхийлэл, нөхөн үржихүйн эрх, үндэсний аюулгүй байдал болон бусад хүний эрхийн аль ч асуудлууд дээр засгийн газрууд хэрхэн хүн бүрийн эрхийг хамгаалах ёстойг тодруулж өгдөг.

Монголын Эмнести Интернэшнлээс УИХ-д нэр дэвшигч нарт хандан уриалж байгаа хүний эрхийн чухал асуудлаарх тоймыг та дараах жагсаалтаас үзнэ үү. Эдгээр асуудлаарх нэр дэвшигчдийн үзэл баримтлал юу бол? Хэрэв УИХ-д сонгогдвол тухайн нэр дэвшигч Монгол улсад болон дэлхий дахинд хүний эрхийг өмгөөлж, хамгаалах асуудлаар хэрхэн ажиллах бол? Нам бус байгууллага болохынхоо хувьд Монголын Эмнести Интернэшнл нь аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчийг дэмжих буюу эсэргүүцдэггүй,

сонгуульд нөлөөлдөггүй. Гэхдээ бид бүх нэр дэвшигчдэд хүний эрхийг түгээн дэлгэрүүлж, хамгаалахыг нэн тэргүүнд чухалчлан үзэж, бодлого, практикийнхаа нэг хэсэг байлгахыг уриалдаг. Тухайлбал:

- Хүний эрхийн боловсрол, үнэт зүйлийг дээдлэн, түгээн дэлгэрүүлэх, хүн төвт бодлого боловсруулах;
- Хүний эрх хамгаалагчийн эсрэг гарч буй айлган сүрдүүлэлт, халдлага, заналхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үр нөлөө бүхий хууль эрх зүйн орчин бий болгох;
- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх харилцааг зохицуулж буй хууль, тогтоомжийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлж, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах;
- Эрүүдэн шүүж, зүй бус харьцсан гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах тусгай албыг бий болгож, эрүүдэн шүүхтэй тууштай тэмцэх;
- Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг бататгах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн шударгаар шүүлгэх эрхийг хангах;
- Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгаж, хорт бодисын улмаас хүрээлэн буй орчин, иргэд хохирохгүй байх, хүний эрх зөрчигчидтэй хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Хүүхэд хамгааллын талаар цогц бодлого боловсруулан, “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн үр нөлөөг нэмэгдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;
- Цар тахал, халдварт өвчний эсрэг авах бүхий л төрлийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хангах бодлого боловсруулах;
- Хувийн хэвшил, компани, үндэстэн дамнасан корпорацуудын үйл ажиллагаанаас улбаатай хүний эрхийн зөрчлийг арилгах, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бий болгох.